



БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Т.ЭНХЖАРГАЛ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрыг иж
бүрэн камержуулах
Төслийн дугаар: ОРАЖСЗДТГ/202001015

Орхон аймаг
2020 он

НЭГ. ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **ЕБС-ийн хичээлийн байрыг иж бүрэн камержуулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОРАЖСЗДТГ/202001015**

Огноо: **2020 оны 01-р сарын 08-ны өдөр**

Жаргалант сумын ЗДТГазар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ЕБС-ийн хичээлийн байрыг иж бүрэн камержуулах** ажлыг гүйцэтгэх тухай **ЦАХИМ** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэхүү харьцуулалтын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийг илгээхийн өмнө 20000 /хорин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн саналыг **2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 09.00 минут**-аас өмнө www.tender.gov.mn сайтаар орж өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч www.tender.gov.mn сайтаар дамжуулан цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 01 дугаар сарын 16-ны 09 цаг 30 минутад Жаргалант сумын ЗДТГ-ын Хурлын зааланд** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ
Нутгийн удирдлагын ордон
Утас:70397202

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - *Үнийн санал маягтаар*
 - *Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь*
 - *Ажил гүйцэтгэх хуваарь*
 - *Улсын бүртгэлийн гэрчилгээ / эх хувиас / ирүүлэх*
 - *Шаардлагатай тусгай зөвшөөрөл: Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /эх хувиас / ирүүлэх.*
Тусгай зөвшөөрөл нь гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ ДУУСАХ ХҮРТЭЛ ХУГАЦААНД ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙНА.
 - *Тендерт оролцогчийг төлөөлөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах бол төлөөлөгч этгээдийн итгэмжлэл, итгэмжлэгчийн иргэний үнэмлэх эх хувиас ирүүлэх*
 - *Харъяа татварын байгууллагын цахим тодорхойлолт*
 - *Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт ирүүлэх / эх хувиас скайнердах*
 - *Сүүлийн 2 жилийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн жагсаалт, үнийн дүн, гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн актыг хавсаргах /Шаардлага:Сүүлийн 2 жилд санал болгож буй үнийн дүнтэй дүйцэх ижил төрлийн ажил хийж гүйцэтгэсэн туршлагатай байх/*
 - *Сүүлийн 2 жилийн гүйцэтгэсэн ажлын одоогийн чанар байдлын талаар захиалагч болон ашиглагч байгууллагын баталгаажуулсан тодорхойлолтыг тус тус эх хувиар ирүүлэх./2018,2019 он/*
Өмнөх гэрээт ажлаа дутуу болон чанаргүй хийж гүйцэтгэсэн бол татгалзах үндэслэл болно.
 - *2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт.*
 - *Тендерт оролцогч нь ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх ИТАжилтан, мэргэжлийн ажилтан, ажилчид, техник тоног төхөөрөмжийн*

чадавхитай. Үүнд:

- ❖ Инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг ирүүлэх ба диплом мэргэжлийн үнэмлэхийг эх хувиас ирүүлэх
 - ❖ Техник тоног төхөөрөмжийн жагсаалт, нотлох баримт
- Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг ажлын зураг төсөл, төсөв, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлнэ.
 - Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа мэдэгдэл эх хувиар ирүүлнэ.
 - Техникийн тодорхойлолтыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд тодорхойлолтын дагуу ажил гүйцэтгэх тухай мэдэгдлийг эх хувиас ирүүлэх
 - Харьяа татварын байгууллага, Нийгмийн даатгал, Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, харилцагч бүх банк болон бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг тендерийн баримт бичигт хавсаргаж ирүүлнэ.
 - Тендерийн бичиг баримтны гадаад хэл дээрх баримт материалуудыг албан орчуулга хийж ирүүлнэ.
 - Ажлын төсөв ирүүлэх (эрх бүхий төсөвчнөөр хийлгэж баталгаажуулсан байх)
Жич: Магадлашгүй ажлын зардал, Захиалагчийн хяналтын зардал, зураг төсөв, норм нормативийн сангийн зардлыг төсөвт зохих зааврын дагуу, мөн татвар, хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ.
Хэрэв Үнийн хөнгөлөлт үзүүлсэн бол ямар зардлаас үзүүлэх тухай үндэслэлээ тайлбар, нотлох баримтаар гаргаж тендерт ирүүлнэ.

Дээрх бичиг баримтуудыг PDF хэлбэрт шилжүүлэн цахим хэлбэрээр ирүүлнэ. Харилцагч байгууллага захиалагч нарын тодорхойлолтуудын огноо тендер зарласан хугацаанд байх, мэдээллүүдийг товъёоглон хуудсыг дугаарлан ирүүлэх ба мэдээллийг ирүүлээгүй буюу худал мэдээлэл ирүүлсэн нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно

4. Тендерийн үнэ

- 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
- 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон

нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. /Техникийн тодорхойлолтыг хангаж буй талаар нотлох баримт ирүүлнэ, Тендер зарлагдсан өдрөөс хойшхи хугацаанд тодорхойлолтуудыг авсан байх шаардлагатай/
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> ➤ Үнийн санал маягтаар ➤ Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь ➤ Ажил гүйцэтгэх хуваарь ➤ Улсын бүртгэлийн гэрчилгээ / эх хувиас / ирүүлэх ➤ Шаардлагатай тусгай зөвшөөрөл: Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /эх хувиас / ирүүлэх. Тусгай зөвшөөрөл нь гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ ДУУСАХ ХҮРТЭЛ ХУГАЦААНД ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙНА. ➤ Тендерт оролцогчийг төлөөлөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах бол төлөөлөгч этгээдийн итгэмжлэл, итгэмжлэгчийн иргэний үнэмлэх эх хувиас ирүүлэх ➤ Харьяа татварын байгууллагын цахим тодорхойлолт ➤ Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт ирүүлэх / эх хувиас скайнердах ➤ Сүүлийн 2 жилийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн жагсаалт, үнийн дүн, гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн актыг хавсаргах /Шаардлага:Сүүлийн 2 жилд санал болгож буй үнийн дүнтэй дүйцэх ижил төрлийн ажил хийж гүйцэтгэсэн туршлагатай байх/ ➤ Сүүлийн 2 жилийн гүйцэтгэсэн ажлын одоогийн чанар байдлын талаар захиалагч болон ашиглагч байгууллагын баталгаажуулсан тодорхойлолтыг тус тус эх хувиар ирүүлэх./2018,2019 он/ Өмнөх гэрээт ажлаа дутуу болон чанаргүй хийж гүйцэтгэсэн бол татгалзах үндэслэл болно. ➤ 2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт. ➤ Тендерт оролцогч нь ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх ИТАжилтан, мэргэжлийн ажилтан, ажилчид, техник тоног төхөөрөмжийн чадавхитай. Үүнд: <ul style="list-style-type: none"> ❖ Инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг ирүүлэх ба диплом мэргэжлийн үнэмлэхийг эх хувиас ирүүлэх ❖ Техник тоног төхөөрөмжийн жагсаалт, нотлох баримт ➤ Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг ажлын зураг төсөл, төсөв, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлнэ. ➤ Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа мэдэгдэл эх хувиар ирүүлнэ. ➤ Техникийн тодорхойлолтыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд тодорхойлолтын дагуу ажил гүйцэтгэх тухай мэдэгдлийг эх хувиас ирүүлэх ➤ Харьяа татварын байгууллага, Нийгмийн даатгал, Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, харилцагч бүх банк болон бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг тендерийн баримт бичигт хавсаргаж ирүүлнэ. ➤ Тендерийн бичиг баримтны гадаад хэл дээрх баримт материалуудыг албан орчуулга хийж ирүүлнэ. ➤ Ажлын төсөв ирүүлэх (эрх бүхий төсөвчнөөр хийлгэж

	<p><i>баталгаажуулсан байх)</i></p> <ul style="list-style-type: none"> ➤ Тухайн ажилд ашиглагдах бараа материалын сертификат, гарал үүслийн гэрчилгээг ирүүлэх. ➤ Магадлашгүй ажлын зардал, Захиалагчийн хяналтын зардал, зураг төсөв, норм нормативийн сангийн зардлыг төсөвт зохих зааврын дагуу, мөн татвар, хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ. <p>Хэрэв Үнийн хөнгөлөлт үзүүлсэн бол ямар зардлаас үзүүлэх тухай үндэслэлээ <u>тайлбар, нотлох баримтаар</u> гаргаж тендерт ирүүлнэ.</p> <p>Дээрх бичиг баримтуудыг PDF хэлбэрт шилжүүлэн цахим хэлбэрээр ирүүлнэ. Харилцагч байгууллага захиалагч нарын тодорхойлолтуудын огноо тендер зарласан хугацаанд байх, мэдээллүүдийг товъёоглон хуудсыг дугаарлан ирүүлэх ба мэдээллийг ирүүлээгүй буюу худал мэдээлэл ирүүлсэн нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Огноо: 2020 оны 01 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: Жаргалант сумын ЗДТГ-ын Хурлын зааланд нээнэ. Аймаг, хот: Орхон аймаг, Жаргалант сум Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2019 оны 01 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут</p>

ЗАДАРГАА

№	Төсвийн задаргаа	Бүгд төсөвт өртөг
1	Ажиллах хүчний зардал	
2	Материал	
3	Тээвэр	
4	Машин ашиглалт	
5	Нэмэгдэл зардал	
6	Ашиг	
7	НӨАТ	
8	Нормчлолын сан	
9	Захиалагчийн албаны зардал	275505
10	Зураг төсөл	137753
11	Зохиогчийн хяналтын зардал	280000
12	Магадлашгүй ажлын зардал	275505
13	Бусад нэмэгдэл зардал	
	НИЙТ ДҮН	

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ – /Хяналтын төсвөөс харна уу. /

а/ Ажлын тоо хэмжээг үнэлэх санамж:

1. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ үнэлэгдэх ажлын тоо хэмжээний жагсаалт болон тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт зэргийг бодит байдалтай холбож нягтлан үзэхийг анхааруулж байна.
2. Гэрээнд тусгайлан заагаагүй нөхцөлд тендерт ирүүлсэн үнийн саналд ажлын тоо хэмжээнд тохирсон үнэд барилгын ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, ажиллах хүчний хөлс, материал, түүний элэгдэл засвар, нийгмийн ба эрүүл мэнд, үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн зардлууд, ашиг бүх төрлийн татвар хураамж, /НӨТ, гаалийн татвар г.м/ банкны үйлчилгээний шимтгэл, үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалттай бүх зардлууд /сорилт, туршилт, баталгаажуулалт, гадаад ажилтнуудын ирэх, буцах болон тэдгээрийн Монгол улсад ажиллуулахтай холбогдсон зардал, ажилчдын байрлах байр, ажилчдыг зөөх унаа г.м/ мөн нэмэгдэл дайвар ба захиалагчийн техник хяналтын зардал болон гэрээний үүрэгт хамруулах ёстой бусад үүрэг хариуцлагыг тооцож шингээсэн байна.
3. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ шинэчлэгдсэн программын дагуу үнэлж, үнэлгээнд техник хяналт, магадлашгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсвийн үнэ, нормчлолын санг тооцож оруулна. Ажлын тоо хэмжээг тооцсон төсвийн дүн нь тендерт ирүүлж буй үнийн саналтай ижил байна. Хэрэв хөнгөлөлт үзүүлсэн бол ямар зардлаас гэдгээ тендерийн маяганд бичиж ирүүлнэ.
4. Ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг үнэлэхдээ ажил гүйцэтгэх технологийн дагуу ажил, ажилбаруудаар задалж нэгжийн норм үнэлгээгээр үнэлэхийг анхааруулж

байна. Гэхдээ нэгжийн норм үнэлгээ дотроо тусгагдсан ажилбаруудыг дахин давтан үнэлсэн байж болохгүй.

5. Талбайгаас гарсан хог хаягдалыг Хот тохижуулах газрын зөвшөөрөгдсөн хогийн цэгт тээвэрлэж зайлуулахаар зардлыг тооцож ирүүлнэ.
6. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан, санал болгосон хугацаанд, ажлыг чанартай хийж, дуусган хүлээлгэж өгөх баталгааг бичгээр гаргаж тендерт ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. /Баталгааг хэрэгжүүлээгүй тохиолдолд гэрээний үүргийн биелэлтийг хангаагүйд тооцно./
7. Тендерт оролцогч нь захиалагчийн тавьсан шаардлага, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээний дагуу ажлыг гүйцэтгэх тухай албан мэдэгдлийг эх хувиар ирүүлнэ.

Дээрхи техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болохоос гадна шалгарсан тохиолдолд захиалагчийн төлөөлөгч эрхийнхээ дагуу ажлыг зогсоож зөрчлийг арилгуулсны үндсэн дээр ажлыг үргэлжлүүлнэ.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж: ЕБС-ийн хичээлийн байрыг иж бүрэн камержуулах

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Ажил гүйцэтгэх график ирүүлэх

БАТЛАВ:

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА *Т. Энхжаргал* Т.ЭНХЖАРГАЛ

КАМЕРИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Баримтлах норм дүрэм:

Гүйцэтгэгч нь зургийн дагуу БД 43-101-03 Цахилгаан байгууламж, MNS 5843-2008 Хамгаалалтын дохиоллын тоног төхөөрөмжийн техникийн үндсэн үзүүлэлт, угсралт суурилуулалт, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

Гадна зориулалтын хяналтын камер. IP66 стандарттай тоос шороо, ус нэвтэрэхгүй -40° $\sim 50^{\circ}$ температурт ажилладаг байна. Гадна зориулалтын хяналтын камер чигийн камер 3 мегапексл, 360 градус иргэдэг камер нь 3 мегапексл 20-30м зүүмтэй, дотор камер чигийн 3 мегапекслтэй байна. Сүлжээний утас UTP 6E кет утас, камерийн дэлгэц 24 инч нимгэн хөвгөн HDMI оролттой, свич 24тэй байна.

Ажлыг хийж гүйцэтгэхийн өмнө захиалагч байгууллага болон зургийн аворт ажилд хэрэглэх материалын тохирлын гэрчилгээ, Монгол улсын стандартыг хангасан гэрчилгээг үзүүлж ажлыг эхлүүлнэ.

ХТББЗ-ын
ХББЗ-ын
-19-

Батлав Жаргалант сумын засаг дарга

Б. Зоригтбаяр

Зөвшөөрсөн "ХББЗА" ОНӨУГ-ын захирал

Б. Мөнхдалай

Зургийн шифр ХББЗА-12/2018

Төсвийн шифр БЗА 17/2018

Жаргалант сумын сургуулийн гадна, дотор орчинг камержуулах ажлын төсөв

Төсөвт өртөг 16 146 335 төгрөг

"ХББЗА" ОНӨУГ-ын
Төсөв зохиосон: Төсөвчин

Л. Энхцэцэг

Орхон аймаг

2018 он

ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭГДСЭН ТОВЧОО

Д/Д	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
		2 738 885
1	Ажиллах хүчний зардал	7 325 000
2	Материал	510 006
3	Тээвэр	351 193
4	Машин ашиглалт	10 925 084
	Шууд зардлын дүн	1 053 396
5	Нэмэгдэл зардал /73.8 %/	1 796 772
6	Ашиг / 15%/	13 775 252
	Барилга угсралтын ажлын дүн	1 377 525
7	НӨАТ 10%	24 795
8	Нормчлолын сан 0.18%	15 177 572
	Дүн	275 505
9	Захиалагчийн албаны зардал	280 000
10	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	137 753
11	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	15 870 830
	Дүн	275 505
12	Магадлашгүй ажил 2%	0
13	Бусад нэмэлт зардал	16 146 335
	Дүн	



ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

ТЫН КАМЕРЫН АЖИЛ

Л	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Гүйцэтгэх ажлын нэр	Дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт (үндсэн ажил / тэт ачиж буулгах)					
				Зэрэг	Нэгж хүн-цаг	Бүгд хүн-цаг	Тарифт цалин	Нийт цалин	Бүгд цалин
7	ш	27	Дотор ажиллах хяналтын камерын иж бүрдэл угсрах	5.0 / 2	8.34 /	225.153 /	3546 / 2371	798393 /	798.393
7	ш	4	Гадаа ажиллах хяналтын камерын иж бүрдэл угсрах	5.0 / 2	8.34 /	33.356 /	3546 / 2371	118280 /	118.280
4	ш	1	Хяналтын дэлгэц угсрах 42инч	5.0 / 2	14.59 /	14.593 /	3546 / 2371	51747 /	51.747
6	ш	30	Сүлжээний утасны толгой	5.0 / 2	1.44 /	43.26 /	3546 / 2371	153400 /	153.400
8	ш	1	Сүлжээний зангилаа /Switch/ угсрах	4.0 / 2	0.92 /	0.916 /	3076 / 2371	2818 /	2.818
4	ш	1	DVR төхөөрөмж угсрах 16 сувагтай	4.8 / 2	5.2 /	5.203 /	3452 / 2371	17961 /	17.961
4	ш	1	Хард дискн хамт угсрах /4tb/	4.8 / 2	5.2 /	5.203 /	3452 / 2371	17961 /	17.961
4	1км	0.34	Сувагчлалаар кабель сүвлэх 1м нь 2кг хүртэл жинтэй	2.4 / 2	181.35 /	61.66 /	2490.6 / 2371	153570 /	153.570
3	метр	340	Утас далдлагч угсрах	3.0 / 2	0.08 / 0.05	28.22 / 15.98	2670 / 2371	75347 / 37889	113.236

Нийт Хүн/цаг:

417.56 / 15.98

Үндсэн цалин:

1 427 365

Инженер техникийн ажилчдын цалин:

242 652

Нэмэгдэл цалин:

528 125

Нийт цалин:

2 198 142

Нийгэмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлөх шимтгэлийн дүн:

241 796

Ажлын багаж, хувцас, хэрэгслэл:

298 947

Ажиллах хүчний зардал:

2 738 885

МАТЕРИАЛ БА ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

Материалын нэр	Материал				Тээвэр				
	Х/Н	Үнэ	Нийт орц	Зардал	Нийт жин	Зай	Зэрэг	Тариф	Зардал
Сүлжээний утас	км	1000000	0.34	340000	4.08	371	2	280.66	424 829
Сүлжээний утасны толгой	ш	1000	30	30000	0.1032	371	2	280.66	10 746
Сүлжээний зангилаа /switch/	ш	160000	1	160000	0.0004	371	2	280.66	45
Утас далдлагч	м	2000	340	680000	0.051	371	3	391.34	7 405
Хяналтын дэлгэц 42инч	ш	600000	1	600000	0.516	371	2	280.66	53 728
Хард диск /4tb/	ш	380000	1	380000	0.0103	371	2	280.66	1 075
Гадаа ажиллах хяналтын камерын иж бүрдэл	ш	290000	4	1160000	0.0138	371	2	280.66	1 433
Дотор ажиллах хяналтын камерын иж бүрдэл	ш	135000	27	3645000	0.0929	371	2	280.66	9 671
DVг төхөөрөмж 16 сувагтай	ш	330000	1	330000	0.0103	371	2	280.66	1 075

Хувь хэмжээний зардал

7 325 000

0 0293

510 006

0

0

НИЙТ БАРИЛГЫН МАШИН МЕХАНИЗМЫН ХЭРЭГЦЭЭ

фр	Машин механизмын нэр	Нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ
28	Автокран 5тн	1.78	59489	105 652
36	Гагнуурын аппарат	2.7	19064	51 397
	Үйлчилгээний машин	33.47	5800	194 144

351 193

"Хот айгуулалт, Барилга захиалагчийн алба" ОНӨУГазар

Шифр: ХББЗА-12/2018

Орхон аймаг, Жаргалант сумын сургуулийн гадна, дотор камержуулалт

/Схем зураг /


Зөвшөөрөлцсөн

БОЛОВСРУУЛСАН:

Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Гүйцэтгэгч	Албан тушаал	Хот байгуулалт
			ХББЗА	"ХББЗА" ОНӨУГ-ын захирал	Нэр: Гарын үсэг
			Захиалагч		Б.Мөнхдалай
				Албан тушаал /мргэн /	Нэр
				Жаргалант сумын ЗДТГ	Гарын үсэг
					<i>М. Доржпүрэв</i>



Нэгдүгээр давхрын камержуулалтын байгуулалт / А-Блок / М 1:200



Дотор камерийн үзүүлэлт


1	1.3MP 1/3 Progressive scan CMOS
2	Support dual streams
3	Up to 30meters IR range
4	-S- Two-way audio
5	-S- Audio/Alarm I/O
6	IR cut filter with auto switch
7	DC 12V and PoE



Тайлбар
Орхон адмаг Жаргалант сумын сурагуулийн 4ш дотор 27ш камерийг зураг төсөөт завсан тоо хэмжээ мөрийн дагуу хийж гүйцэтгэнэ. Зураг төсөөнд ХББЗА- "ОНӨҮГ"-т хийж гүйцэтгэнэ.

ХББЗА	Орхон адмаг Жаргалант сумын сурагуулийн 4ш дотор 27ш камерийг зураг төсөөт завсан тоо хэмжээ мөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.	ХББЗА- "ОНӨҮГ"-т хийж гүйцэтгэнэ.	МЭ 200	Төлөө	Б	2018 он
	Төсний нэр					
ХББЗА	ХББЗА- "ОНӨҮГ"-т хийж гүйцэтгэнэ.	ХББЗА- "ОНӨҮГ"-т хийж гүйцэтгэнэ.	МЭ 200	Төлөө	Б	2018 он

Хоёрдугаар давхрын камержуулалтын байгуулалт / А-Блок/ М 1:200



Гадна камерийн үзүүлэлт

1	1/3 Progressive scan CMOS
2	Up to 4 megapixel resolution
3	120dB Wide Dynamic Range
4	3D DNR
5	EXIR high performance LEDs
6	Up to 30/50/80 meters IR range
7	12V DC 25% and PoE




Материалын тунгав

Д/а	Материалын нэр	Скалам м²	Метр м
1	Дотор камер	12	27
2	Гадна камер	12	4
3	Кабель утас	12	340
4	Данжуу 42 inch	12	1
5	DVR Бичлэг (бууцаг 16)	12	1
6	Утас данжуулагч	12	340


Орлого өлсгөл, Жарганын гэмтлүүдийг явдан дүгнэлт өргөн хянаж байна		БА
Бас өлсгөл	А. Зүрбэт	МТ 300
Архитектор	Б. Чингис	Нэгдэл зэр. Дайдын байгуулалт
Туслахчид	Б. Чингис	Утас
Гүйцэтгэгч	Д. Тодоржавтн	Цэвэр хэргийн үйлчилгээний байр ХХЭБХА-122018
ХЭБХА		2018 он

Нэгдүгээр давхрын камержуулалтын байгуулалт /Б-Блок/ М 1:200




ХБСГА	Орлог аймаг Жаргалант сумын суурiumын аймга бэлтгэж байгаа байгуулалт			БА		
	Хяса аллага	А.Элмээт	М 1:200			
	Ариунгасар Гүйцэтгэсэн	Б.Цэцэгс	Тусгай	Тусгай	Тусгай	
	Итгэлээр	Д.Т.Ж.Эрбастар	Шийдвэр: ХБСГА-1202018	А.З	З	Б
2018 он						

Хоёрдугаар давхрын камержуулалтын байгуулалт /Б-Блок/ М 1:200



Орхон аймаг, Жаргалант сумын суурium сэдвийг дагуу орхи байгуулалт		БА	
Хэргийн Аргумент	А. Энхбат	М 1:200	Биеэцгээх 5
Түргэлжсэн	Б. Чингис	А3 4	
Илалт	Д. Сүх-орболор	Шийрэг: ХББЗА-120018	2018 он
ХББЗА			

Урлаг заалны камержуулалтын байгуулалт М 1:200



		Орхон аймгаас Жаргалант сумын суурингийн явцаг бичлэгээр орчны газар зураг		БА	
Хэсгийн А. Заал	А. Заал	Хэсгийн Б. Цэнгэ	Б. Цэнгэ	М1:200	Тусламж
Архитектор Г. Уялсүрэн	Г. Уялсүрэн	Урлаг заалны байгуулагч Шивэр ХББЗА-192018	Шивэр ХББЗА-192018	А3	5
Ижтэйгч Д. Т. Ж. Рагзор	Д. Т. Ж. Рагзор			Б	5
ХББЗА					2018 он

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Т.ЭНХЖАРГАЛ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгааар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгааар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр** **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын

талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ЕБС-ийн хичээлийн байрыг иж бүрэн камержуулах ОРАЖСЗДТГ/202001015
ГЕН 2.1	Ажил нь : ЕБС-ийн хичээлийн байрыг иж бүрэн камержуулах бүрдэнэ.
ГЕН 3.1	Төслийн менежер нь Гэрээний хэлэлцээр хийх үед тодорхойлно.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр Гэрээ батлагдсан өдрөөс эхлэн ажил эхлэх өдөр тооцогдоно. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр Уг ажлыг хуанлийн 30 хоногт хийж гүйцэтгэнэ.
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [5] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа: МУ-ын барилгын тухай хуулийн 14.3 Барилга байгууламжийг ашиглалтанд зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. 14.6 Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсоноос хойш барилга байгууламжийн гадна дотор засал, бүх төрлийн материал, үндсэн, үндсэн хийц, бүтээц, цэвэр бохир ус ,уур, хий, дулаан цахилгаан харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3 жилээс доошгүй байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0.05 хувь] байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [5 хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [3 хоногийн] -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [5 хоногийн] -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [тухайн материалыг бэлтгэхэд гарах зардлын хэмжээтэй тэнцүү] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [00 хувь] -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

